

## АГУУЛГА



Бүртгэлтэй ажилгүйчүүд



Эрүүл мэнд



Банк



Төсөв



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ



Хөдөө аж ахуй



Аж үйлдвэр



Цахилгаан холбоо

## **Аргачлалын тайлбар**

### **Нийгмийн даатгал, халамж**

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

### **Эрүүл мэнд**

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гаргаж авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөх болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

### **Мөнгө, банк**

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгийг банкнаас гадуурх мөнгө болон касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Бага мөнгө /M1/-ийг банкнаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Төгрөгийн харилцах дансан дахь мөнгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Бараг мөнгийг төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

Төгрөг болон валютын хадгаламжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Валютын харилцахыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Мөнгөний нийлүүлэлт /M2/-ийг банкнаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тооцно. Өөрөөр хэлбэл бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Хэвийн зээл гэж төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээлийг зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлно.

Чанаргүй зээлийг хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тооцож гаргана.

### Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нэг өрхөөс бус нийт өрхөөр тооцогдсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашигладаг.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж байна.

$$I_{ct}^L = \frac{\sum P_{it} Q_{io}}{\sum P_{io} Q_{io}}$$

$I_{ct}^L$  -t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t –тайлант үе, 0 – суурь үе,

$P_{it}$  -'i' барааны тайлант үеийн үнэ,

$P_{io}$  -'i' барааны суурь үеийн үнэ,

$Q_{io}$  -'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

$\sum$  -нийлбэрийн тэмдэг

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний сагсан дахь нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), хэрэглээний зардлын жинг шинэчилж, 2012 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн индексийг тооцоход ашиглаж байна.

Хөдөө аж ахуйн гол нэрийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээг сум, аймгийн үнэ цуглуулах нэгжүүдээс сар бүр авч, сарын дундаж үнийг тооцож байна.

### Хөдөө аж ахуй

Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ. Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, гол мөрөн, худаг хавцалд унах зэрэг хариулга маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

## **Нэгдсэн төсөв**

Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээг Монгол улсын Сангийн сайдын 2015 оны 1 сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар төсвийн ангиллаар 2015 оны 1 дүгээр сараас эхлэн гаргаж байна. Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлага нь улсын төвлөрсөн төсвөөс шууд санхүүждэг төсвийн байгууллагуудын болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтсээс сар бүр гаргаж статистикийн хэлтэст ирүүлдэг.

Орон нутгийн төсөв нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ. Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар, татварын орлогын төрлүүдээр харууллаа. Төвлөрсөн төсвийн орлого нь улсын төсвийн санхүүжилт, татварын бус орлогоос бүрдэнэ.

## **Аж үйлдвэр**

Аж үйлдвэрийн салбарт нийт үйлдвэрлэл нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуй нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуй нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, үйлдвэрлэлийн биет хэмжээний индексийг тооцно.

## **Хөдөлмөр**

Эдийн засгийн идэвхитэй хүн ам(ажиллах хүч)-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч , нийлүүлэхэд бэлэн байгаа ажилдгүй иргэдийг хамруулна.

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2017 оны 01 дүгээр сарын байдал)

## Бүртгэлтэй ажилгүй иргэн

Аймгийн Хөдөлмөр , Халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 1 дүгээр сарын байдлаар 845 байгаагийн 54.2 хувь нь буюу 458 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 80 хүнээр буюу 8.6 хувиар буурчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл 283 нь дээд, 37 нь тусгай дунд, 89 нь техник мэргэжлийн, 357 нь бүрэн дунд, 43 нь суурь, 32 нь бага, 4 нь ямар ч боловсролгүй байна хүмүүс байна.

### Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2017 оны 01 сарын эцэст, дүнд эзлэх хувиар




### Бүртгэлтэй ажилгүй иргэд, жил бүрийн 01 сарын байдлаар



2015 оны 1 сар    2016 оны 1 сар    2017 оны 1 сар


### Бүртгэлтэй ажилгүй иргэд, 01 сарын байдлаар насны бүлгээр



## Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2017 оны 01 сарын байдлаар 87 эх амаржиж 87 хүүхэд мэнд төрлөө. Нялхсын эндэгдлийн 1 тохиолдол бүртгэгджээ.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн 01 сарын байдлаар




Эндсэн хүүхэд, жил бүрийн 01 сарын байдлаар



Цочмог халдварт өвчин 57 бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс 4.1 дахин нэмэгдсэн байна. .

Халдварт өвчнөөр өвчлөгчид, 01 сарын байдлаар



## Банк

Мөнгөний нийлүүлэлт /M2/ 2017 оны 1 дүгээр сарын эцэст 65.4 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 3.8 тэрбум төгрөг буюу 5.5 хувиар буурчээ.

**Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст сая төг**


Үзүүлэлт		
	2015-XII	2016-I
<b>Мөнгөний нийлүүлэлт M2</b>	<b>69205.0</b>	<b>65420.8</b>
Сарын өөрчлөлт, хувиар	7.2	-5.5
<b>Нийт хадгаламж</b>	<b>58826.7</b>	<b>55941.1</b>
Сарын өөрчлөлт, хувиар	6.6	-4.9
<b>Төгрөгийн хадгаламж</b>	<b>57960.7</b>	<b>55246.8</b>
Сарын өөрчлөлт, хувиар	7.1	-4.6
<b>Валютын хадгаламж</b>	<b>866.0</b>	<b>694.3</b>
Сарын өөрчлөлт, хувиар	-19.9	-19.8

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 712.8 сая төгрөг болж, өмнөх сарынхаас 915.9 сая төгрөг буюу 56.2 хувиар буурчээ.

Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 1 дүгээр сарын эцэст 89.6 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 0.8 тэрбум төгрөг буюу 1.4 хувиар өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 1 дүгээр сарын эцэст 0.9 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 0.1 тэрбум төгрөг буюу 14.1 хувиар өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.0 хувийг эзэлж байна.


Чанаргүй зээл 2017 оны 1 дүгээр сарын эцэст 1.5 тэрбум төгрөг болж өмнөх сарынхаас 53.8 сая төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.7 хувийг эзэлж байна.

**Чанаргүй зээл, сарын эцэст, сая төг**




## Төсвийн орлого

Орон нутгийн төсөвт нийт 4 тэрбум 644.8 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 117.1 хувиар, үүнээс татварын орлого 314.6 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 95.4 хувиар биелүүлсэн байна. Татварын бус орлого 4 тэрбум 606.9 сая, тусгай зориулалтын шилжүүлгээс 3 тэрбум 498.7 сая, орон нутгийн хөгжлийн сангийн орлогоос 97.4 сая, улсын төсвөөс 4 тэрбум 596.9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан байна.



## Төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтын 66.1 хувийг зарцуулав. Үүнд цалин хөлс нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 85.5 хувь, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 80.5 хувь, бараа үйлчилгээ бусад зардлын 34.6 хувийг тус тус зарцуулсан байна.




## Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2017 оны 1 дүгээр сард өмнөх сараасаа 2.7 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2.9 хувь, суурь үеийнхээс 58.2 хувиар өсчээ.

Ерөнхий индекс 2017 оны 1 дүгээр сард өмнөх сарынхаас 2.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн индекс 5.8, тээврийн салбарын бүлгийн индекс 12.2 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Энэ бүлгийн үнийн индекс өсөхөд тухайн бүлэгт өндөр хувийн жин эзэлдэг мах 500-1300 төгрөг, бензин 100-150 төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

### ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2017-01 2010-12	2017-01 2016-01	2017-01 2016-12
<b>Ерөнхий индекс</b>	<b>100</b>	<b>158.2</b>	<b>102.9</b>	<b>102.7</b>
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	152.5	105.2	105.8
Согтууруулах ундаа, тамхи	3.2	221.5	99.8	100.0
Хувцас, бөс бараа, гутал	16.1	164.1	103.4	100.4
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	145.3	99.5	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	154.4	103.1	100.0
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	118.7	100.0	100.0
Тээвэр	12.2	136.3	98.0	112.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	96.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	118.0	99.4	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	393.6	109.1	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	192.5	103.5	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	140.3	98.6	100.0



### Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ


Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгаагаар 2017 оны 1 дүгээр сард аймгийн төв болох Есөнбулаг суманд үхрийн шир 30.0 мян.төг, адууны шир 40.0 мян.төг, хонины арьс 1.5 мян.төг, ямааны арьс 33.0 мян.төгрөгний үнэ ханштай байна.

### Хөдөө аж ахуй

2017 оны 1 дүгээр сарын байдлаар үнээ 1, эм хонь 644, эм ямаа 510 нийт 1155 мал төллөж 1152 төл бойжиж байна.

Эхний 1 сард аймгийн хэмжээнд 917 толгой мал зүй бусаар хорогдсон ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.6 дахин бага байна. Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл, адуу 15, үхэр 5, тэмээ 4, хонь 252, ямаа 641 байна. Нийт хорогдлын 27.5 хувийг хонь, 69.9 хувийг ямаа эзэлж байна.


## Зүй бусаар хорогдсон том мал



## Аж үйлдвэр



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны эхний 1 дүгээр сард 1 тэрбум 441.2 сая төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 5.4 хувиар буурчээ. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 39 хувийг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, 38 хувийг дулаан эрчим хүч үйлдвэрлэл, 4 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 14 хувийг нүүрс олборлолт, 5 хувийг усан хангамжийн салбар тус тус эзэлж байна. Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 79.6 хувийг буюу 1 тэрбум 147.1 төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулсан байна.

## Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн, 1 сарын байдлаар, салбараар, сая.төг




## Цахилгаан холбоо компани

Суурин телефон цэгийн тоо 786, холбооны газрын орлого 22.5 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 15.7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.



### 2017 оны 02 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээ

**Говь-Алтайн нутгаар.** Энэ сарын агаарын температурын дундаж нь Говь-Алтайн баруун хойд хэсгээр уур амьсгалын дунджаас 0,5-1.0 градусаар дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй (3 дугаар зураг).



Нэгдүгээр арав хоногийн эхээр хүйтний эрч суларч Алтайн өвөр говиор шөнөдөө 10-15 градус хүйтэн, өдөртөө 3градус хүйтнээс 2 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 16-21 градус, өдөртөө 4-9 градус хүйтэн байна. Мөн гуравдугаар арав хоногийн дунд үеэс хүйтний эрч ихэнх нутгаар харьцангуй суларна. Нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхний хагаст Алтайн өвөр говиор шөнөдөө 17-22градус, өдөртөө 7-12градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 25-30 градус, өдөртөө 14-19градус хүйтэн байна. Бусад хугацаанд Алтайн өвөр говиор шөнөдөө 14-19 градус, өдөртөө 3-8градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 20-25 градус, өдөртөө 9-14 градус хүйтэн байна.



Энэ сард орох хур тунадас нь Говь-Алтайн баруун хэсгээр уур амьсгалын дунджийн орчим, бусад нутгаар дунджаас ахиуорох төлөвтэй(4 дүгээр зураг) Нэгдүгээр арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр бага зэргийн цас орно. Хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр ихэнх нутгаар, гуравдугаар арав хоногийн дунд үеболон сүүлчээр зарим газраарцас орно.Салхи нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр нутгийн өмнөд хагаст 16-18м/с, гуравдугаар арав хоногийн сүүлчээр Алтайн уулархаг нутгаар түр зуур 20-24 м/с хүрч цасан болон шороон шуурга шуурах төлөвтэй.

**ХӨДӨЛМӨР  
LABOUR**

**БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, тайлант хугацааны эцэст  
NUMBER OF REGISTERED UNEMPLOYED, at the end of period**

Боловсролын түвшингээр	By educational level	2013.XII	2014.XII	2015.XII	2016.XII	1-cap	
						In January	
						2016	2017
<b>Бүгд</b>	<b>Total</b>	<b>1214</b>	<b>1241</b>	<b>1044</b>	<b>786</b>	<b>925</b>	<b>845</b>
Үүнээс: эмэгтэй	of which:female	669	699	547	435	486	458
Дээд боловсролтой	Higher education	259	327	252	265	256	283
Тусгай дунд боловсролтой	Specialized secondary education	481	477	72	35	55	37
Мэргэжлийн анхан шатны	Professional technical and vocational training workers	37	37	81	70	68	89
Бүрэн дунд	Upper secondary school	287	270	483	341	414	357
Суурь	Compulsory secondary school	96	87	112	42	93	43
Бага	Primary school	45	34	35	28	34	32
Боловсролгүй	Uneducated persons	9	9	9	5	5	4

**АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, насны бүлгээр, 2017 оны 1-р сарын эцэст**  
**NUMBER OF UNEMPLOYED, by age group, at the end of January 2017**

Үүнээс: насны бүлгээр of which: by age group

Cap Months	Бүгд Total	Үүнээс: эмэгтэй female	16- 24	25- 34	35- 44	45- 59	55- 59	60+
			Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female	Эмэгтэй female
I	845	458	157	315	199	139	27	8

**АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, боловсролын түвшингээр, 2017 оны 1-р сарын эцэст**  
**NUMBER OF UNEMPLOYED PERSONS, by educational level, at the end of January 2017**

Cap Month	Бүгд Total	Дээд боловс- ролтой Higher education	Тусгай дунд боловсролтой Specialized secondary educatoin	Мэргэжлийн анхан шатны Skilled workers	Бүрэн дунд боловсролтой Completed secondary school	Суурь боловсролтой Noncompleted secondary school	Бага боловс- ролтой Completed primary school	Боловсролгүй Uneducated persons
I	845	283	37	89	357	43	32	4

**АЖИЛГҮЙЧҮҮД, 2017 оны 1 сард ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ХҮН**  
**NUMBER UNEMPLOYED AND NEWLY REGISTERED PERSONS, in the 1 month of 2017**

Cap	Month	Ажилгүйчүүдийн тоо, 1-р сарын эцэст			1-р сард шинээр бүртгүүлсэн ажилгүй хүн		
		Number of unemployed, at the end of 1 months			Number of unemployed newly registered in the 1 months		
		2016	2017	2017% 2016	2016	2017	2017% 2016
I		925	845	91.4			

**АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, СУМДААР**  
**NUMBER OF UNEMPLOYED, by som**

Сум	Sum	Ажилгүйчүүдийн тоо Number of unemployed						
		2013.XII	2014.XII	2015.XII	2016.XII	1-р сар in January		
						2016	2017	2017% 2016
Есөнбулаг	Yesunbulag	271	488	284	326	301	321	106.6
Алтай	Altai	27	11	40	10	25	12	48.0
Баян-Уул	Bayan-Uul	19	12	22	40	22	62	2.8 дахин
Бигэр	Biger	53	23	56	35	56	38	67.9
Бугат	Bugat	22	33	26	19	26	20	76.9
Дарив	Darib	44	32	47	17	47	18	38.3
Дэлгэр	Delger	25	29	45	44	45	46	102.2
Жаргалан	Jargalan	18	26	33	11	33	10	30.3
Тайшир	Taishir	9	10	17	15	17	16	94.1
Тонхил	Tonhil	32	38	68	20	68	24	35.3
Төгрөг	Tugrug	37	18	37	21	37	26	70.3
Халиун	Haliun	21	16	35	25	35	26	74.3
Хөхморьт	Huhmorit	15	12	15	34	15	37	2.4 дахин
Цогт	Tsogt	61	40	73	61	21	61	2.9 дахин
Цээл	Tseel	12	22	37	15	37	14	37.8
Чандмань	Chandmani	44	16	75	34	16	39	2.4 дахин
Шарга	Sharga	19	27	46	34	32	42	131.3
Эрдэнэ	Erdene	39	11	25	25	25	33	132.0
Бусад аймгууд болон УБ-т бүртгэлтэй	Other	446	373	63		67		0.0
<b>ДҮН</b>	<b>TOTAL</b>	<b>1214</b>	<b>1237</b>	<b>1044</b>	<b>786</b>	<b>925</b>	<b>845</b>	<b>91.4</b>

**ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**  
**PUBLIC HEALTH OF POPULATION**

№	Сумын нэр	Soum	төрсөн эх <i>Women who gave births</i>		эхийн эндэгдэл <i>Maternal Deaths</i>		төрсөн хүүхэд <i>Births</i>		Нялхасын эндэгдэл <i>Infant mortality</i>		1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл <i>Under-five mortality</i>		Нийт нас баралт <i>Deaths</i>		Эмнэлэгт нас баралт <i>Deaths</i>	
			2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016
1	Есөнбулаг	<i>Yesunbulag</i>	91	79			91	79	1	1			5	8	1	2
2	Алтай	<i>Altai</i>	2				2						2	2	1	1
3	Баян-Уул	<i>Bayan-Uul</i>		2				2					3	1		
3	Бигэр	<i>Biger</i>	1	1			1	1						1		
4	Бугат	<i>Bugat</i>											2		1	
5	Гуулин	<i>Gulin</i>												1		
5	Дарив	<i>Darib</i>														
6	Дэлгэр	<i>Delger</i>		1				1					3		1	
7	Жаргалан	<i>Jargalan</i>												2		2
8	Тайшир	<i>Taishir</i>											1			
8	Тонхил	<i>Tonhil</i>		2				2					1		1	
9	Төгрөг	<i>Tugrug</i>											2		2	
10	Халиун	<i>Haliun</i>											1			
10	Хөхморьт	<i>Huhmorit</i>												1		1
11	Цогт	<i>Tsogt</i>											2	1	1	1
12	Цээл	<i>Tseel</i>	1	1			1	1					1		1	
12	Чандмань	<i>Chandmani</i>														
13	Шарга	<i>Sharga</i>											1	2		
14	Эрдэнэ	<i>Erdene</i>		1				1						3		
15	Баянтоорой	<i>Bayantoroi</i>											1		1	
<b>22</b>	<b>Дүн</b>	<b>Total</b>	<b>95</b>	<b>87</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>95</b>	<b>87</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>25</b>	<b>22</b>	<b>10</b>	<b>7</b>

№	Сумын нэр	Soum	Цочмог халдварт өвчлөл бүгд Infectious Diseases		Үүнээс: Of which:															
			БЗХӨ STID										Гепатит Hepatite		Сүрьеэ Tuberculosis		Улаан бурхан		бусад Other	
			трихоминаз Trichomoniasis		тэмбүү Syphilis		заг хүйтэн Gonorrhea													
			2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016	2015	2016		
1	Есөнбулаг	Yesunbulag	13	34			4	6		1			1		5		3	27		
2	Алтай	Altai		1				1												
3	Баян-Уул	Bayan-Uul																		
3	Бигэр	Biger		1														1		
4	Бугат	Bugat		2			1		1											
5	Гуулин	Gulin																		
5	Дарив	Darib	1	1			1					1								
6	Дэлгэр	Delger		2					1				1							
7	Жаргалан	Jargalan		1			1													
8	Тайшир	Taishir		3		1				2										
8	Тонхил	Tonhil																		
9	Төгрөг	Tugrug		1					1											
10	Халиун	Haliun		2														2		
10	Хөхморьт	Huhmorit		4			4													
11	Цогт	Tsogt																		
12	Цээл	Tseel		2			2													
12	Чандмана	Chandmani		1			1													
13	Шарга	Sharga		2			1						1							
14	Эрдэнэ	Erdene																		
15	Баянтоорой	Bayantoroi																		
<b>22</b>	<b>Дүн</b>	<b>Total</b>	<b>14</b>	<b>57</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>4</b>	<b>18</b>	<b>0</b>	<b>6</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>5</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>30</b>		

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО  
GOVI-ALTAI AIMAGS GOVERNMENT REVENUE, by classification of revenue

<b>мян.төг tous.tog</b>				
ОРЛОГЫН ТӨРӨЛ	<i>INCOME TYPE</i>	Төлөвлөгөө <i>Project</i>	Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
<b>ОРОН НУТГИЙН ОРЛОГО</b>		<b>3967400.7</b>	<b>4644802.7</b>	<b>117.1</b>
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>329831.4</b>	<b>314585.2</b>	<b>95.4</b>
Орлогын албан татвар		301687.4	19688.6	6.5
Хувь хүний орлогын албан татвар		301687.4	19688.6	6.5
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэхтэй холбоотой орлого		285401.0	99.4	0.0
Үйл ажиллагааны орлого		6473.2	12906.0	199.4
Хөрөнгийн орлого		3000.0	0.0	0.0
Хөрөнгө борлуулсны орлого		6813.2	6683.1	98.1
Шууд бус орлого		6813.2	6683.1	98.1
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	0.0	0.0
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлого		0.0	0.0	0.0
Хөрөнгийн албан татвар		7218.8	630.0	8.7
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар		5959.7	0.0	0.0
Бууны албан татвар		1220.0	630.0	51.6
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар		39.1	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж		20925.2	17496.4	83.6
Бусад нийтлэг төлбөр, хураамж		18956.2	17452.1	92.1
Улсын тэмдэгтийн хураамж		7958.0	7060.8	88.7
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр		0.0	14.5	0.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж		10998.2	10376.8	94.3
Бусад татвар		0.0	0.0	0.0
Газрын төлбөр		1969.0	0.0	0.0
Газрын төлбөр		1969.0	0.0	0.0
Байгалийн нөөц ашигласны төлбөр		0.0	42.3	0.0
Ойн нөөц ашигласны төлбөр		0.0	30.0	0.0
Ан амьтны нөөц ашигласны төлбөр		0.0	0.0	0.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр		0.0	12.3	0.0
Бусад татвар		0.0	2.0	0.0
Нохойны албан татвар		0.0	2.0	0.0
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>3637569.3</b>	<b>4606987.7</b>	<b>126.7</b>
Нийтлэг татварын бус орлого		30674.3	10034.2	32.7
Хүүгийн орлого		0.0	0.0	0.0
Торгуулийн орлого		20640.0	3076.2	14.9
Төсөв байгууллагын өөрийн орлого		9604.7	6545.5	68.1
Түрээсийн орлого		349.6	200.0	57.2
Бусад орлого		80.0	212.5	265.6
Хөрөнгийн орлого		0.0	0.0	0.0
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого		0.0	2850.0	0.0
Өмч хувьчлалын орлого		20800.0	5201.5	25.0
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг		3606895.0	4596953.5	127.4
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг		0.0	1000879.7	0.0
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого		3498668.9	3498675.5	100.0
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого		108226.1	97398.3	90.0
Эргэж төлөгдөх зээл		1812175.1	1672241.8	92.3
Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		0.0	0.0	0.0

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА  
EXPENDITURE OF PROVINCIAL GOVERNMENT

мян.төг, tous.tog

	Төлөвлөгөө <i>Project</i>	Гүйцэтгэл <i>Performance</i>	Хувь <i>Rate</i>
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>5309952.8</b>	<b>3507882.3</b>	<b>66.1</b>
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2146652.2	1834661.3	85.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	236605.7	190407.6	80.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	635187.8	474506.1	74.7
Хангамж бараа материалын зардал	116703.3	45828.8	39.3
Нормативт зардал	225744.2	100682.5	44.6
Эд хогшил, урсгал засварын зардал	37780.9	3422.2	9.1
Томилолт зочны зардал	21855.3	11248.0	51.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	94838.2	26980.5	28.4
Бараа үйлчилгээний бусад зардал	88204.9	30545.7	34.6
ТАТААС	7000.0	6000.0	85.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1269119.7	742599.6	58.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	265256.2	16000.0	6.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3967400.7	4644802.7	117.1
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3967400.7</b>	<b>4644802.7</b>	<b>117.1</b>
Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	3498668.9	3498675.5	100.0
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	108226.1	97398.3	90.0
ТӨСӨВ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС САНХҮҮЖИХ	2398673.4	1735664.8	72.4

ТАТВАРЫН ОРЛОГО ГҮЙЦЭТГЭЛ сумаар  
PERFORMANCE REVENUE soum

№	Сум	Soum	мян.төг tous.tog		
			Нийт орлого		Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
			Project	Performance	Rate
1	Есөнбулаг	Yesunbulag	20,000.0	23,905.4	119.5
2	Алтай	Altai	580.0	1,393.4	3 дахин
3	Баян-Уул	Bayn-Uul	630.0	916.3	2 дахин
4	Бигэр	Biger	97.0	0.0	2 дахин
5	Бугат	Bugat	433.2	0.0	0.0
6	Дарив	Dariv	475.0	883.6	4 дахин
7	Дэлгэр	Delger	100.0	541.2	541.2
8	Жаргалан	Jargalan	851.2	554.5	65.1
9	Тайшир	Taishir	297.0	359.3	121.0
10	Тонхил	Tonhil	1,000.0	882.4	88.2
11	Төгрөг	Tugrug	100.0	820.0	820.0
12	Халиун	Khaliun	518.2	0.0	0.0
13	Хөхморьт	Khukhmorit	216.0	1,094.5	506.7
14	Цогт	Tsogt	925.0	1,317.2	4 дахин
15	Цээл	Tseel	400.0	4,309.9	1077.5
16	Чандмань	Chandmani	885.0	0.0	0.0
17	Шарга	Sharga	550.0	231.9	5 дахин
18	Эрдэнэ	Erdene	920.0	882.7	95.9
19	Баянтоорой тосгон	Bayntooroi	475.0	22.7	4.8
20	Гуулин тосгон	Guulin	10.0	0.0	0.0
21	Татварын хэлтэс	Straight communicant	300,368.8	276,470.2	92.0
	<b>Дүн</b>		<b>329,831.4</b>	<b>314,585.2</b>	<b>95.4</b>

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ сумаар

PERFORMANCE REVENUE soum

№	Сум	Soum	мян.төг		
			Орон нутаг Provincial government		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
			Project	Performance	Rate
1	Есөнбулаг	Yesunbulag	8,386,110.7	7,407,706.7	88.3
2	Алтай	Altai	1,359,992.6	1,257,449.9	92.5
3	Баян-Уул	Bayn-Uul	1,247,787.5	1,075,644.4	86.2
4	Бигэр	Biger	1,100,367.3	910,967.1	82.8
5	Бугат	Bugat	1,381,204.7	1,184,548.0	85.8
6	Дарив	Dariv	1,396,212.4	1,176,569.1	84.3
7	Дэлгэр	Delger	1,340,524.2	1,123,045.1	83.8
8	Жаргалан	Jargalan	1,054,828.3	890,819.8	84.5
9	Тайшир	Taishir	974,407.9	849,137.8	87.1
10	Тонхил	Tonhil	1,409,106.4	939,653.2	66.7
11	Төгрөг	Tugrug	1,178,762.6	1,001,043.0	84.9
12	Халиун	Khaliun	1,182,328.2	940,689.0	79.6
13	Хөхморьт	Khukhmorit	1,337,217.4	1,190,210.0	89.0
14	Цогт	Tsogt	1,519,857.2	1,280,486.4	84.3
15	Цээл	Tseel	1,308,698.5	1,016,047.7	77.6
16	Чандмань	Chandmani	1,206,629.6	1,001,640.8	83.0
17	Шарга	Sharga	1,158,462.6	999,907.7	86.3
18	Эрдэнэ	Erdene	1,325,482.4	1,108,865.2	83.7
19	Гуулин тосгон	Guulin	707,586.3	637,510.3	90.1
20	Баянтоорой тосгон	Bayntooroi	702,737.6	608,244.8	90.1
21	Шууд харилцагч	Straight communicant	12,891,718.8	9,822,839.7	86.6
	<b>Дүн</b>		<b>44170023.2</b>	<b>36,423,025.9</b>	<b>76.2</b>

МӨНГӨ, ЗЭЭЛ, ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ  
MONEY, LOAN, STOCK MARKET

I. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ, сарын эцэст  
MONEY SUPPLY, at the end of months

Хугацаа, сараар Periods, by months	Мөнгө M2 Money M2	Мөнгө M1 Money M1			Бараг мөнгө Quasi money	Төгрөгийн хадгаламж Time deposit in DC	Валютын хадгаламж Time deposits in FC	Валютын харилцах Current account in FC	Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө Currency issued in circulation
		Төгрөгийн харилцах Current account	Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө Currency outside depository corporations						
2017 он									
I	65,420.80	9,436.71	10,608.66	(1,171.95)	55,984.09	55,246.85	694.27	42.98	712.80

II. АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, зээлийн ангиллаар, сарын эцэст  
LOANS OUTSTANDING, by classification of loan, at the end of months

Хугацаа, сараар Periods, by months	Зээлийн өрийн үлдэгдэл Laons outstanding	Хэвийн зээл Standart loans	Хугацаа хэтэрсэн зээл Principal in arrears	Чанаргүй зээл Non performing laons	Төрийн салбар Public sector	Хувийн салбар Private sector	Иргэд Individuals	Бусад Other
I	89,601.23	87,177.21	875.50	1,548.52	-	129.26	1,419.27	-

## ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ

## ANNUAL AVERAGE PRICES

2017.02.04

Бараа/Сум	Goods/Sum	Алтай Altai	Баян-Уул Bayan-Uul	Бигэр Biger	Бугат Bugat	Дарив Dariv	Дэлгэр Delger	Жаргалан Jargalan	Тайшир Taishir	Тонхил Tonkhil	Төгрөг Tugrug	Халиун Khaluun	Хөхморьт Khuukmorit	Цогт Tsogt	Цээл Tseel	Чандмань Chandmani	Шарга Sharga	Эрдэнэ Erdene	Есөнбулаг Yesunbulag
Гурил \А.Т-1\, 1кг	Flour, grade 1, kg	1120	1000	1080	1000	1400	950	1100	1300	1000	1200	1080	1200	1040	1300	950	1000	1200	1300
Гурил \Орос\, 1кг	Flour, Russian, kg	1040	0	1800	1400	1140	0	0	0	1000	1000	0	1100	0	1350	0	900	1200	1000
Жигнэмэг./Янзагатай/ дотоод	Biscuit, domestic	300	300	500	500	500	350	600	0	600	500	500	700	450	800	500	600	500	300
Цагаан будаа./Сайн чанарын/ 1кг	Rice,/best quality/, kg	2500	2500	2500	2500	2850	2500	2500	2500	2500	2800	2300	2500	2500	2500	2500	2200	2500	2500
Шар будаа,1кг	Millet, kg	2500	2200	2000	2000	1800	1800	2000	1500	1800	2500	2000	2300	2500	2000	2300	1800	2000	1800
Элсэн чихэр,1кг	Sugar, kg	2500	2500	2500	2500	2500	2500	2500	2500	2500	2800	2500	2800	2500	2400	2500	2500	2500	2500
Чихэр, /Барбарис/ 1 кг	Candy, kg	7000	6000	5000	7000	6000	6000	7000	5500	5500	5500	6500	7000	6000	7000	6500	5000	6000	6000
Ногоон цай \ Мөнгөн аягатай\	Green tea, 2 kg	10000	6000	9000	7000	9900	6500	8500	6000	7000	6000	6500	10000	7000	9000	7000	7000	8000	6500
Давс \iodжуулсан\ 1 кг	Salt, iodated, kg	1000	1000	1000	1000	1000	800	1000	1000	800	1000	1000	1000	800	1000	1000	1000	1000	1000
Ургамлын тос, л/Санни/	Vegetable oil, l	4000	3500	3800	4500	4200	3800	3800	3500	3800	3800	3500	4000	3500	3800	4500	3800	4500	3500
Архи, дотоод, 0.5 л /Ерөөл/	Alcohol, domestic, 0.5 l	10000	8500	8500	8500	8800	8000	7500	8000	8000	7000	8000	8000	8000	8000	8500	7500	8000	7500
Дүнсэн тамхи \Орос\	Making, Russian	13000	5500	9000	10000	11000	7500	11000	10000	10000	10000	11000	12000	9500	10000	8500	8500	10000	7000
Шүдэнз \орос\	Match, Russian	600	600	700	700	500	600	600	600	500	800	600	700	500	500	0	400	600	500
Марль 1м	Gauze, m	1800	1200	1500	1000	1000	700	1500	1500	1200	1000	1200	1800	1500	1500	1500	1300	1500	1000
Эдийн саван /ОК/	Laundry soap	800	800	800	1000	800	800	900	800	700	800	800	800	800	800	800	700	900	600
Угаалгын нунтаг\ОМО\400 гр ууттай	Washing detergent /ОМО/400gr	2800	2500	3000	2500	2900	2500	3600	3000	2500	3500	2800	3000	2500	3500	3000	2500	3500	2500
Цоохор даавуу \Хямд\ 150 см өргөнтэй	Cotton cloth /distress prices/ wide 150sm	8500	4000	4200	3000	8000	0	2500	0	5500	5500	0	5000	5000	4000	0	3500	3000	2500
Лаа \Хятад\	Candle, China	700	300	350	400	350	500	500	450	350	500	400	500	350	400	500	300	500	300
Нүүр гарын саван \LUX\	Beauty soap, LUX	900	800	900	1000	800	800	1000	900	800	1000	1000	1200	800	1500	1000	800	900	500
Шүдний оо, ш, \PS\ 130 гр том	Tooth-paste, PS, 130g big	2800	1800	1800	2000	2000	1500	2500	2000	1500	1500	2200	1500	2500	2000	2000	1800	2000	1800
Радионы зай \Хятад\, 1ш	Battery, china	800	600	600	700	600	600	800	800	800	600	800	600	1000	500	600	500	500	500
Янжуур \ Улаан шонхор\	Cigarette, Ulaan shonkhor	2000	1800	2000	2000	1900	2000	1700	2000	1800	1800	2000	1700	1800	1800	2000	1900	2000	1700
Бензин, АИ-80, 1л	Petrol "AI-80" litre	1850	1600	1850	1620	1500	1800	1600	1600	1700	1650	1570	1600	1790	1500	1640	1550	1850	1650
Сумаас аймаг орох нэг талын зардал	Cost of travel	30000	10000	10000	18000	18000	5000	12000	4000	18000	15000	10000	15000	20000	18000	20000	7000	25000	0
Цахилгаан задгай, 1кВт.ц	Electricity, 1kWt.h	120	113	90	102.7	102.4	102.7	102.4	122.2	124.2	102.4	110	124.2	110	124.2	122.9	124.2	110	112.6



ТӨЛ БОЙЖИЛТЫН МЭДЭЭ, багаар,

Сум	Баг	Төллөсөн хээлтэгч						Гарсан төл						Хорогдсон төл						Бойжсон төл					
		Бүгд	Гүү	Үнээ	Ингэ	Эм хонь	Эм ямаа	Бүгд	Унага	Тугал	Ботго	Хурга	Ишиг	Бүгд	Унага	Тугал	Ботго	Хурга	Ишиг	Бүгд	Унага	Тугал	Ботго	Хурга	Ишиг
<b>Бүгд</b>		<b>1155</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>644</b>	<b>510</b>	<b>1155</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>644</b>	<b>510</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>1152</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>641</b>	<b>510</b>
Алтай	Бадрал	14		1		13		14		1		13		0						14		1		13	
Баян-Уул	Чандмань хайрхан	15				15		15				15		0						15				15	
	Баянговь	60				40	20	60				40	20	0						60				40	20
Бигэр	Хүрэмт	120				100	20	120				100	20	0						120				100	20
Дарив	Ихэс	16				11	5	16				11	5	0						16				11	5
Жаргалан	Бүрэн	95				55	40	95				55	40	0						95				55	40
	Завхан гол	10				10		10				10		3				3		7				7	
Тайшир	Хуримт	20				20		20				20		0						20				20	
	Далан	115				80	35	115				80	35	0						115				80	35
Төгрөг	Төгрөгийн эх	350				50	300	350				50	300	0						350				50	300
Эрдэнэ	Сангийн далай	60				40	20	60				40	20	0						60				40	20
	Цэцэг нуур	53				53		53				53		0						53				53	
	Цагаан-Уул	133				83	50	133				83	50	0						133				83	50
	Өлзийт	94				74	20	94				74	20	0						94				74	20

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДЛЫН МЭДЭЭ, багаар

Сум	Баг	Хорогдсон том мал					Өвчнээр хорогдсон том мал					Хорогдсон хээлтэгч мал							
		Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
	<b>Бүгд</b>	<b>917</b>	<b>15</b>	<b>5</b>	<b>4</b>	<b>252</b>	<b>641</b>	<b>28</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>10</b>	<b>18</b>	<b>179</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>65</b>	<b>113</b>
Есөнбулаг	1-р баг, Баянхайрхан	37	0	0	0	11	26	2	0	0	0	1	1	4	0	0	0	1	3
	2-р баг, Баяншанд	24	0	0	0	5	19	2	0	0	0	1	1	5	0	0	0	1	4
	3-р баг, Жаргалант	20	0	0	0	4	16	1	0	0	0	0	1	4	0	0	0	1	3
	4-р баг, Харзат	8	0	0	0	2	6	0	0	0	0	0	0	4	0	0	0	1	3
	5-р баг, Рашаант	56	0	1	0	10	45	2	0	0	0	1	1	7	0	0	0	2	5
	6-р баг, Наран	50	0	0	0	15	35	2	0	0	0	1	1	5	0	0	0	2	3
	7-р баг, Жинст	28	0	0	0	5	23	2	0	0	0	1	1	7	0	0	0	2	5
	8-р баг, Индэрт	22	0	0	0	5	17	1	0	0	0	0	1	4	0	0	0	1	3
	9-р баг, Түмэн	40	0	0	0	5	35	2	0	0	0	1	1	6	0	0	0	1	5
	10-р баг, Оргил	27	0	0	0	10	17	2	0	0	0	1	1	10	0	0	0	5	5
Алтай	1-р баг, Бадрал	18	0	3	2	5	8	0	0	0	0	0	0	5	0	0	0	2	3
	2-р баг, Баянцагаан	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	3-р баг, Урт	23	1	0	1	7	14	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Баян-Уул	4-р баг, Баян-Овоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	1-р баг, Баян богд	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	2-р баг, Чандмань хайрхан	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	3-р баг, Баянхайрхан	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	4-р баг, Хүйсийн говь	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	5-р баг, Баянговь	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бигэр	6-р баг, Алтангадас	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	1-р баг, Мянгай	30	1	0	0	14	15	0	0	0	0	0	0	11	1	0	0	4	6
	2-р баг, Урт	20	2	0	0	5	13	0	0	0	0	0	0	6	0	0	0	2	4
	3-р баг, Их булаг	22	2	0	0	8	12	7	0	0	0	3	4	0	0	0	0	0	0
	4-р баг, Буудай	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Бугат	5-р баг, Хүрэмт	23	2	0	0	9	12	0	0	0	0	0	0	6	0	0	0	2	4
	1-р баг, Биж	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	2-р баг, Ферм	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	3-р баг, Гаханч	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	4-р баг, Сүж	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дарив	5-р баг, Баянгол	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	1-р баг, Ихэс	4	0	0	0	0	4	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	2-р баг, Хужирт	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	3-р баг, Жавхлант	81	5	1	0	21	54	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дэлгэр	4-р баг, Үйлдвэр	4	0	0	0	2	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	1-р баг, Баян-Өндөр	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	2-р баг, Баянхонгор	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	3-р баг, Баянбуурал	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	4-р баг, Баянсан	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Жергалан	5-р баг, Гуулин	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	1-р баг, Бүрэн	25	0	0	0	10	15	0	0	0	0	0	0	7	0	0	0	4	3
	2-р баг, Тээл	9	0	0	0	3	6	0	0	0	0	0	0	5	0	0	0	2	3
	3-р баг, Завхан гол	47	0	0	0	17	30	0	0	0	0	0	0	19	0	0	0	7	12



**АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН сумаар,оны үнээр**  
**INDUSTRIAL OUTPUT, by som, at current price**

**GROSS**

		мян.төг / thous.tug/			
Сумд	Som	2016.I	2017.I	Дүнд эзлэх хувь Percentage share to total	
				2016	2017
<b>Нийт дүн</b>	<b>Total</b>	<b>1525355.1</b>	<b>1441245.3</b>	<b>100.00</b>	<b>100.00</b>
Есөнбулаг	Yesunbulag	1379188.6	1277049.8	90.42	88.61
Алтай	Altai	7138.8	4663.8	0.47	0.32
Баян-Уул	Bayan-Uul	1672.1	1628.9	0.11	0.11
Бигэр	Biger	2928.7	2934.2	0.19	0.20
Бугат	Bugat	8200.6	6774.6	0.54	0.47
Дарив	Darib	32697.7	32384.3	2.14	2.25
Дэлгэр	Delger	1608.7	7442.9	0.11	0.52
Жаргалан	Jargalan	1628.9	1849.9	0.11	0.13
Тайшир	Taishir	24986.6	24582.7	1.64	1.71
Тонхил	Tonhil	2257.3	2948.3	0.15	0.20
Төгрөг	Tugrug	1888.4	2460.2	0.12	0.17
Халиун	Haliun	1571.4	1440.2	0.10	0.10
Хөхморьт	Huhmorit	3509.1	4777.3	0.23	0.33
Цогт	Tsogt	1784.2	3120.9	0.12	0.22
Цээл	Tseel	15402.8	6578.2	1.01	0.46
Чандмань	Chandmani	20831.3	36061.4	1.37	2.50
Шарга	Sharga	3649.2	2341.2	0.24	0.16
Эрдэнэ	Erdene	14410.5	22206.3	0.94	1.54

**АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ** сумаар,оны үнээр  
**GROSS INDUSTRIAL OUTPUT, by som, at current price**

Сумд	Som	2016.I	2017.I	мян.төг / thous.tug/	
				Дүнд эзлэх хувь Percentage share to total	
				2016	2017
<b>Нийт дүн</b>	<b>Total</b>	<b>1280300.8</b>	<b>1147062.9</b>	<b>100.00</b>	<b>100.00</b>
Есөнбулаг	Yesunbulag	1090215.2	936433.2	85.2	81.6
Алтай	Altai	4625.5	3182.0	0.36	0.28
Баян-Уул	Bayan-Uul	5442.6	5375.6	0.43	0.47
Бигэр	Biger	8762.4	8746.9	0.68	0.76
Бугат	Biger	5266.9	4195.1	0.41	0.37
Дарив	Darib	31315.7	34961.8	2.45	3.05
Дэлгэр	Delger	4171.0	15028.3	0.33	1.31
Жаргалан	Jargalan	5375.6	3803.6	0.42	0.33
Тайшир	Taishir	35411.2	41421.0	2.77	3.61
Тонхил	Tonhil	4649.5	5442.6	0.36	0.47
Төгрөг	Tugrug	3839.8	4620.8	0.30	0.40
Халиун	Haliun	5250.5	4841.5	0.41	0.42
Хөхморьт	Huhmorit	5495.6	8918.4	0.43	0.78
Цогт	Tsogt	5996.9	10364.2	0.47	0.90
Цээл	Tseel	9688.3	4096.9	0.76	0.36
Чандмань	Chandmana	31461.6	26190.5	2.46	2.28
Шарга	Sharga	7103.9	4625.5	0.55	0.40
Эрдэнэ	Erdene	16228.7	24815.1	1.27	2.16

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ  
 MAIN INDICATORS OF TELECOMMUNICATION SECTOR

		Өмнөх оны мөн үед Previous year	2017 оны I сард		
			Төлөвлөгөө Project	Гүйцэтгэл Performance	Хувь Percent
Харилцаа холбооны үйлчилгээний орлого мян.төг	<i>Revernue from telecommunication services thous.tog</i>	16000.0	25859.6	22468.0	86.9
Хүн амаас олсон орлого мян.төг	<i>Revernue from population thous.tog</i>	11500.0	18102.0	15728.0	86.9
Суурин утасны цэгийн тоо	<i>Number of tellepnone lines</i>	816	975	786	80.6
Үүнээс: Хүн амаас Суурин утасны цэгийн тоо	<i>of which population tellepnone lines</i>	590	685	441	64.4